



НИЙСЛЭЛИЙН
СТАТИСТИКИЙН
ГАЗАР



НИЙСЛЭЛИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2025 VII



www.ubstat.mn



Улаанбаатар хот
2025 он



**НИЙСЛЭЛИЙН
СТАТИСТИКИЙН
ГАЗАР**

АГУУЛГА

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2021-2025 он	4
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	4
I	Эрүүл мэнд	6
II	Гэмт хэрэг	10
III	Төсөв	14
IV	Хэрэглээний үнэ	18
V	Аж үйлдвэр	24
VI	Барилга	31
VII	Хотын нийтийн аж ахуй	36
VIII	Цаг уур, агаарын чанар, аюулт үзэгдэл, осол	38

Хүснэгт 1. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, дүүргээр

Үзүүлэлт		Хэмжих нэгж	2021 I-VII	2022 I-VII	2023 I-VII	2024 I-VII	2025 I-VII
Шинээр төрсөн хүүхэд		Хүн	21 779 ↓6.5	19 432 ↓10.8	20 471 ↑5.3	18 338 ↓10.4	17 219 ↓6.1
Халдварт өвчнөөр өвчлөгчид		Хүн	124 524 ↑12.6**	161 820 ↑30.0	14 250 ↓91.2	10 875 ↓23.7	27 307 ↑2.5**
Бүртгэгдсэн гэмт хэрэг		Тоо	8 031 ↓21.9	15 578 ↑94.0	15 499 ↓0.5	17 270 ↑11.4	21 897 ↑26.8
Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)		Хувь	1.4 ↑1.0	0.6 ↓0.8	-0.2 ↓0.8	0.0 ↓0.2	-0.1 ↓0.3
Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж)	Доллар (АНУ)	Төгрөг	2 849 ↑0.2	3 153 ↑10.7	3 442 ↑9.2	3 381 ↓1.8	3 585 ↑6.0
	Юань (БНХАУ)	Төгрөг	440 ↑8.4	468 ↑6.4	479 ↑2.4	466 ↓2.7	500 ↑7.3
	Рубль (ОХУ)	Төгрөг	39 ↓2.5	54 ↑38.5	38 ↓29.6	39 ↑2.6	45 ↑15.4
Нийслэлийн төсвийн орлого		Тэрбум төгрөг	621.9 ↑31.6	769.1 ↑23.7	1 063.0 ↑38.2	1 647.0 ↑54.9	2 139.6 ↑29.9
Нийслэлийн төсвийн зарлага		Тэрбум төгрөг	643.9 ↓9.9	787.8 ↑22.3	1 038.0 ↑31.8	2 204.3 ↑21.1*	2 659.7 ↑20.7
Агаарын дундаж температур		°C	19.2	17.6	17.9	20.1	20.2

Хүснэгт 2. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 I-VII					2025 I-VII				
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	349	Баянгол	8 578	Налайх	59	357	Баянгол	8 797	Налайх	59
			Чингэлтэй	1 526	Багануур	47		Чингэлтэй	1 490	Багануур	47
			Сүхбаатар	679	Багахангай	32		Сүхбаатар	688	Багахангай	32
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	12	Багануур	20	Баянзүрх	9	15	Багануур	19	Баянгол	11
			Багахангай	20	Налайх	8		Налайх	19	Хан-Уул	9
			Баянгол	12	Сүхбаатар	5		Сүхбаатар	15	Багахангай	-
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	67	Баянзүрх	69	Хан-Уул	45	165	Баянзүрх	187	Сонгино-хайрхан	115
			Сүхбаатар	58	Сонгино-хайрхан	43		Багануур	152	Багахангай	51
			Баянгол	51	Багахангай	16		Хан-Уул	143	Налайх	48
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	75	Баянзүрх	131	Багахангай	89	80	Хан-Уул	115	Налайх	83
			Баянгол	116	Налайх	81		Сүхбаатар	110	Багахангай	83
			Сонгино-хайрхан	113	Багануур	32		Баянзүрх	110	Багануур	23
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	161	Сүхбаатар	250	Сонгино-хайрхан	94	198	Сүхбаатар	330	Багануур	122
			Чингэлтэй	192	Багануур	30		Чингэлтэй	278	Налайх	69
			Баянгол	180	Багахангай	47		Баянгол	230	Багахангай	45

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй

* урьдчилсан гүйцэтгэл

** дахин

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/



V. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга =1000

сая=10⁶

тэрүм =10⁹

их аяд =10¹²

мянмянга

% хувь

мммиллиметр

см сантиметр

дм дециметр

м метр

км километр

м² метр квадрат

дм² дециметр квадрат

км² километр квадрат

м³ метр куб

га гектар

мл миллилитр

л литр

г грамм

кг килограмм

цн центнер

т тонн

Вт ватт

кВт.ц киловатт цаг

кал калори

ккал килокалори

Гкал гигакалори(=10⁹ калори)

с секунд

мин минут

мкг/м³ микрограмм метр куб

м/с метр секунд

ш ширхэг

х.д.х

хэвлэлийн даралтат
хуудас



МЭДЭЭЛЭЛ



МЭДЭЭЛЭЛ, ОЙ САНАМЖ



ЭРҮҮЛ МЭНД

2025 оны эхний 7 сард 17062 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 1098(6.0%) төрөлтөөр буурсан байна.

Нийслэлийн хэмжээнд 2025 оны эхний 7 сард 17062 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 1098 (6.0%) төрөлтөөр буурсан байна. Нийт төрөлтийн 8766 (51.4%) нь НЭМГ-ын харьяа эмнэлэгт, 8296 (48.6%) нь нийслэлд

үйл ажиллагаа явуулж буй ЭМЯ-ны харьяа улс болон хувийн хэвшлийн эмнэлэгт амаржсан байна. Нийт амаржсан эхчүүдийн 0.3 хувийг гэрийн төрөлт эзэлж байна.

Хүснэгт 3.

ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, жил бүрийн эхний 7 сарын байдлаар


Үзүүлэлт	2023 I-VII	2024 I-VII	2025 I-VII	Өөрчлөлт %
Амаржсан эхийн тоо	20 334	18 160	17 062	-6.0
Гэрийн төрөлт	76	55	47	-14.5
Хяналтгүй төрөлт	105	164	133	-18.9
Амьд төрсөн хүүхэд	20 471	18 338	17 219	-6.1
Эхийн эндэгдэл	8	3	4	33.3
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	284	224	255	13.8
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	13.9	12.4	14.8	

2025 оны эхний 7 сард 17219 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 1119 (6.1%) хүүхдээр цөөн байна. Төрсөн нийт

хүүхдийн 3299 (19.2%) нь бусад аймгийн харьяат эхчүүдээс мэндэлжээ.

Зураг 1.

АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД, дүүргээр




Төрсөн нийт хүүхдийн 9036 (52.5%) нь хүү, 8183 (47.5%) нь охин байна. Амьд төрсөн нийт хүүхдээс 2 ихэр хүүхэд 246, 3 ихэр хүүхэд 2 байна.

Амьгүй төрөлтийн 91 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 21 тохиолдлоор буурсан байна. Амьгүй төрөлт Сонгинохайрхан, Сүхбаатар, Багануур дүүрэгт хотын дунджаас өндөр байна.

Зураг 2.

ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙН ТҮВШИН (1000 амьд төрөлтөд ногдох)




Нийслэлд 2025 оны эхний 7 сард бүртгэгдсэн нялхсын эндэгдлээс Баянзүрх дүүрэгт 43 (16.9%) нь, Сонгинохайрхан дүүрэгт 39 (15.3%) нь, Хан-Уул дүүрэгт 23 (9.0%) нь, Баянгол дүүрэгт 20 (7.8%) нь, Сүхбаатар дүүрэгт 16 (6.3%) нь, Чингэлтэй дүүрэгт 14 (5.5%) нь, Налайх дүүрэгт 7

(2.7%), Багануур дүүрэгт 4 (1.6%), бусад аймгийн харьяат 89 (34.9%) бүртгэгдэж, Багахангай дүүрэгт бүртгэгдээгүй байна.

Нийслэлд 2025 оны эхний 7 сард 27307 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 16432 (2.5 дахин их) хүнээр өссөн байна.

Зураг 3.

ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД, сараар



Халдварт өвчнөөр өвчлөгчдийг халдварт өвчний төрлөөр нь авч үзвэл амьсгалын замын цочмог халдварт өвчин 17596 (64.4%), бэлгийн замаар дамжих халдварт

өвчин 3417 (12.5%), гэдэсний халдварт өвчин 1231 (4.5%), зоонозын халдварт өвчин 22 (0.1%), бусад халдварт өвчин 5041 (18.5%) байна.

Хүснэгт 4.

НИЙСЛЭЛД БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Төрөл	Хэмжих нэгж	2023 I-VII	2024 I-VII	2025 I-VII	Өөрчлөлт	
					тоо/нэгж хувь	хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн, бүгд	тоо	14 250	10 875	27 307	16 432	2.5**
	10000 хүнд	90.9	67.2	164.6	97.4	
Үүнээс:						
Вируст гепатит	тоо	114	79	104	25	31.6
	10000 хүнд	0.73	0.5	0.63	0.13	
Цусан суулга	тоо	753	719	493	- 226	-31.4
	10000 хүнд	4.8	4.4	2.97	-1.43	
Салхин цэцэг	тоо	4 644	3 588	4 591	1 003	28.0
	10000 хүнд	29.6	22.1	27.67	5.57	
Гахай хавдар	тоо	57	167	51	- 116	-69.5
	10000 хүнд	0.4	1	0.31	-0.69	
Сальмонеллёз	тоо	119	178	189	11	1.1
	10000 хүнд	0.8	1.1	1.1	0.0	
Улаан эсэргэнэ	тоо	591	312	442	130	41.7
	10000 хүнд	3.8	1.9	2.7	0.76	
Хоолны хордлого	тоо	53	151	0	- 151	0.0
	10000 хүнд	0.3	0.90	0.0	-0.90	
Ёлом	тоо	42	0	116	116	-
	10000 хүнд	0.3	0	0.7	0.70	
Бруцеллёз	тоо	6	0	3	3	-
	10000 хүнд	0.04	0	0.02	0.02	
Гар, хөл, амны өвчин	тоо	2256	1125	642	- 483	-42.9
	10000 хүнд	14.4	7	3.9	-3.1	
Тэмбүү	тоо	1489	1893	1597	- 296	-15.6
	10000 хүнд	9.5	11.7	9.6	-2.1	
Гонококкт халдвар	тоо	862	859	938	79	9.2
	10000 хүнд	5.5	5.3	5.7	0.4	
Трихомониаз	тоо	638	608	866	258	1.4
	10000 хүнд	4.1	3.8	5.2	1.4	
Сүрьеэ	тоо	792	801	730	- 71	-8.9
	10000 хүнд	5.1	4.9	4.4	-0.5	
ДОХ	тоо	10	15	16	1	1.1
	10000 хүнд	0.06	0.09	0.1	0.0	
Улаанбурхан	тоо	0	0	11 133	11 133	-
	10000 хүнд	0	0	67.1	67.1	

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг,

өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.



ГЭМТ ХЭРЭГ


Нийслэлд 21897 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4627 (26.8%) хэргээр өссөн байна.

2025 оны эхний 7 сард 21897 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4627 (26.8%) хэргээр өсөж, гэмт хэргийн илрүүлэлт 32.9 хувьтай байгаа нь 0.2 нэгж хувиар буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 3828 хүн гэмтэж осолдон, 387 хүн нас барж, төр ард иргэдэд 369.0 тэрбум төгрөгийн хохирол учруулснаас 1183.2 сая (32.1%) төгрөгийг нөхөн төлүүлжээ.

Зураг 4.

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 42.3 хувийг залилан, 18.0 хувийг хулгайн, 15.5 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 4.8 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг, 1.8

хувийг дээрмийн, 1.6 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 1.5 хувийг бусдын хөрөнгө ашиглах, 1.2 хувийг хүчин, 0.2 хувийг хүн амь, 13.1 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт 5.

БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өөрчлөлт	
	2023 I-VII	2024 I-VII	2025 I-VII	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	15 499	17 270	21 897	4 627	26.8
Хүний амь	72	60	55	-5	-8.3
Хүчин	139	218	261	43	19.7
Дээрэм	245	319	401	82	25.7
Хулгай	2 625	3 841	3 940	99	2.5
Залилан	6 642	5 740	9 260	3 520	61.3
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	3 142	3 316	3 400	84	2.5
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	385	632	1 045	413	65.3
Бусдыг амиа хорлоход хүргэх	131	230	345	115	50.0
Бусдын хөрөнгө ашиглах	270	382	330	-52	-13.6
Бусад гэмт хэрэг	1 848	2 532	2 860	328	13.0

2025 оны эхний 7 сард 5469 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2881 (2.1 дахин их) хүнээр өссөн байна.

Хүснэгт 6. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, дүүргээр

Дүүрэг	Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг			Өөрчлөлт	
	2023 I-VII	2024 I-VII	2025 I-VII	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	15 499	17 270	21 897	4 627	26.8
Багануур	123	173	241	68	39.3
Багахангай	15	14	14	0	0.0
Баянгол	2 633	2 975	3 943	968	32.5
Баянзүрх	3 791	4 822	5 002	180	1.0
Налайх	310	259	185	-74	-28.6
Сонгинохайрхан	2 120	2 087	3 076	989	47.4
Сүхбаатар	2 635	2 379	3 211	832	35.0
Хан-Уул	2 199	2 788	3 686	898	32.2
Чингэлтэй	1 673	1 773	2 539	766	43.2

2025 оны эхний 7 сард бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 19666 (89.8%) нь хөнгөн хэрэг, 2231 (10.2%) нь хүнд хэрэг байна.

Хүснэгт 7. ГЭМТ ХЭРЭГ БҮРТГЭГДЭХ ҮЕД СЭЖИГТНЭЭР ТООЦВОЛ ЗОХИХ ЭТГЭЭД НЬ ТОГТООГДООГҮЙ ХЭРГИЙН ТОО, 2025 оны эхний 7 сард

Дүүрэг	Хэрэг бүртгэлтийн хэргийн тоо	Үүнээс:	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
		Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэрэг	
Нийслэлийн дүн	21 259	6 986	32.9
Багануур	202	104	51.5
Багахангай	12	8	66.7
Баянгол	3 894	1 143	29.4
Баянзүрх	4 854	1 691	34.8
Налайх	183	103	56.3
Сонгинохайрхан	2 934	1 122	38.2
Сүхбаатар	3 133	875	27.9
Хан-Уул	3 585	860	24.0
Чингэлтэй	2 462	1 080	43.9

Зураг 5.

ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТИЙН ХУВЬ, 2025 оны эхний 4 сард

Хамгийн бага 24.0%

Хан-Уул дүүрэг

Хамгийн их 66.7%

Багахангай дүүрэг

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 2025 оны эхний 7 сард 7864 болж, өмнөх оны мөн үеэс 1204 (18.1%) хүнээр буурсан байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 1307 (16.6%) нь согтуугаар, 595 (7.6%) нь бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг байна. Сэжигтэн, яллагдагчийн 353 (4.5%) нь хүүхэд, 945 (12.0%) нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 8.

БҮРТГЭГДСЭН ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГ, дүүргээр

Дүүрэг	Хулгайн гэмт хэргийн тоо, бүгд			Үүнээс:		
				Хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо		
	2023 I-VII	2024 I-VII	2025 I-VII	2023 I-VII	2024 I-VII	2025 I-V
Нийслэлийн дүн	2 625	3 841	3940	2 265	2 702	2750
Багануур	15	26	31	14	22	21
Багахангай	-	4	5	-	4	5
Баянгол	408	617	700	348	413	481
Баянзүрх	627	1 229	892	491	885	667
Налайх	46	27	31	45	19	27
Сонгинохайрхан	515	448	545	471	292	376
Сүхбаатар	471	524	561	410	352	362
Хан-Уул	290	616	748	270	487	527
Чингэлтэй	253	350	427	216	228	284

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000- аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.



НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВ

Нийслэлийн төсвийн нийт орлого 2139.6 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 200.4 тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ.

Нийслэлийн төсвийн нийт орлого 2025 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 2139.6 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 200.4 (8.6%) тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ. Төсвийн нийт орлогын 1846.6 (86.3%) тэрбум төгрөгийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 293.0 (13.7%) тэрбум төгрөгийг татварын бус орлого тус тус эзэлж байна.


2025 оны эхний 7 сарын байдлаар нийслэлийн татварын орлого 1846.6 тэрбум

төгрөг болж, төлөвлөснөөс 167.8 (8.3%) тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 293.0 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 32.6 (10.0%) тэрбум төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн байна.

Орлогын албан татвар 162.4 (9.6%) тэрбум төгрөг, хөрөнгийн албан татвар 10.5 (6.4%) тэрбум төгрөгөөр тус тус дутуу, бусад татвар, төлбөр, хураамж 5.1 (3.3%) тэрбум төгрөгөөр илүү биелсэн байна.

Зураг 6.

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төгрөг



Хүснэгт 9. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2025 оны эхний 7 сарын байдлаар, дүүргээр


Дүүрэг	Төсвийн орлого			Үүнээс					
				Татварын орлого			Татварын бус орлого		
	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь
	сая төгрөг								
Нийслэлийн дүн	2 340 028.9	2 139 640.3	- 8.6	2 014 430.9	1 846 611.5	- 8.3	325 598.0	293 028.8	- 10.0
Багануур	14 473.3	14 514.7	0.3	11 531.5	11 643.1	1.0	2 941.8	2 871.6	- 2.4
Багахангай	1 385.9	1 868.1	34.8	1 150.4	1 296.3	12.7	235.5	571.8	2.4 ¹
Баянгол	204 827.3	162 308.9	- 20.8	201 449.2	159 104.8	- 21.0	3 378.1	3 204.1	- 5.2
Баянзүрх	206 226.9	188 474.7	- 8.6	203 902.5	185 965.9	- 8.8	2 324.4	2 508.8	7.9
Налайх	15 133.8	15 837.3	4.6	13 130.5	14 247.9	8.5	2 003.3	1 589.4	- 20.7
Сонгинохайрхан	109 357.0	90 232.6	- 17.5	107 312.3	88 838.0	- 17.2	2 044.7	1 394.6	- 31.8
Сүхбаатар	377 581.6	349 398.3	- 7.5	375 505.2	346 864.8	- 7.6	2 076.4	2 533.5	22.0
Хан-Уул	349 928.7	295 489.6	- 15.6	347 099.6	291 068.0	- 16.1	2 829.1	4 421.6	56.3
Чингэлтэй	167 914.5	156 609.2	- 6.7	164 043.7	155 117.0	- 5.4	3 870.8	1 492.2	- 61.5
Хотын шууд	893 199.9	864 906.9	- 3.2	589 306.0	592 465.7	0.5	303 893.9	272 441.2	- 10.3

Хүснэгт 10. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2025 оны эхний 7 сарын байдлаар

Үзүүлэлт	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Өөрчлөлт	
	сая төгрөг		Дүн	Хувь
Нийт орлого	2 340 028.9	2 139 640.3	-200 388.6	- 8.6
Татварын орлого	2 014 430.9	1 846 611.5	-167 819.4	- 8.3
Орлогын албан татвар	1697 406.5	1534 994.3	-162 412.2	- 9.6
Хувь хүний орлогын албан татвар	1243 159.1	1094 469.1	-148 690.0	- 12.0
Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын	920 301.8	770 167.0	-150 134.8	- 16.3
Үйл ажиллагааны орлогын	41 276.2	35 848.8	-5 427.4	- 13.1
Хөрөнгийн орлого	93 411.2	96 446.3	3 035.1	3.2
Хөрөнгө борлуулсны орлогын	65 379.3	60 638.2	-4 741.1	- 7.3
Шууд бус орлого	122 790.6	131 368.8	8 578.2	7.0
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-59 999.6	-52 467.0	7 532.6	- 12.6
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	514 247.0	492 992.2	-21 254.8	- 4.1
Хөрөнгийн албан татвар	163 353.9	152 883.3	-10 470.6	- 6.4
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	63 161.8	59 661.6	-3 500.2	- 5.5
Бууны албан татвар	293.2	206.0	- 87.2	- 29.7
Авто тээврийн ба өөрөө явагч хэрэгслийн	99 801.4	92 923.5	-6 877.9	- 6.9
Малд ногдуулах албан татвар	97.5	92.2	- 5.3	- 5.4
Бусад татвар, төлбөр, хураамж	153 670.5	158 733.9	5 063.4	3.3
Бусад нийтлэг төлбөр, хураамж	59 033.4	51 473.5	-7 559.9	- 12.8
Газрын төлбөр	74 314.2	84 684.8	10 370.6	14.0
Байгалийн нөөц ашигласны төлбөр	2 348.6	2 494.2	145.6	6.2
Бусад татвар	17 974.3	20 081.4	2 107.1	11.7
Татварын бус орлого	325 598.0	293 028.8	-32 569.2	- 10.0
Нийтлэг татварын бус орлого	324 598.0	293 028.8	-31 569.2	- 9.7
Хувьцааны ногдол ашиг	766.9	557.4	- 209.5	- 27.3
Төсөвт байгууллагын өөрийн орлого	30 363.5	42 805.5	12 442.0	41.0
Торгуулийн орлого	89 479.2	71 394.4	-18 084.8	- 20.2
Түрээсийн орлого	1 680.0	726.1	- 953.9	- 56.8
Хүүгийн орлого	105 062.2	98 805.9	-6 256.3	- 6.0
Бусад орлого	97 246.2	78 739.5	-18 506.7	- 19.0
Өмч хувьчлал	1 000.0	-	-1 000.0	-

Зураг 7.

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сая төгрөг



Хүснэгт 11.

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2025 оны эхний эхний 7 сарын байдлаар, сая төгрөг


Үзүүлэлт	Зарлага		Өөрчлөлт	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Нийслэлийн дүн	3 827 737.2	2 659 726.1	-1 168 011.1	- 30.5
Багануур	28 535.2	17 555.7	-10 979.5	- 38.5
Багахангай	9 657.0	8 156.9	-1 500.1	- 15.5
Баянгол	205 392.3	163 418.9	-41 973.4	- 20.4
Баянзүрх	210 852.1	172 071.2	-38 780.9	- 18.4
Налайх	23 937.8	19 099.8	-4 838.0	- 20.2
Сонгинохайрхан	137 399.9	99 386.9	-38 013.0	- 27.7
Сүхбаатар	433 622.9	317 262.0	-116 360.9	- 26.8
Хан-Уул	370 288.0	256 300.7	-113 987.3	- 30.8
Чингэлтэй	190 258.6	151 433.0	-38 825.6	- 20.4
Хотын шууд	2 217 793.4	1 455 041.0	-762 752.4	- 34.4

2025 оны эхний 7 сарын байдлаар нийслэлийн төсвөөс нийслэл, дүүргийн байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 2659.7 (69.5%)

тэрбум төгрөгийг санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл нийслэл, дүүргийн байгууллагууд батлагдсан төсвийнхөө 1168.0 (30.5%) тэрбум төгрөгийг зарцуулаагүй байна.

Зураг 8.

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сая төгрөг



Ойлголт, тодорхойлолт:

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн орлого: Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.




ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 9.3 хувиар өслөө.

Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2025 оны 7 дугаар сард нийслэлийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 9.3 хувиар өсөж, өмнөх сараас 0.1 хувиар буурсан байна.

Зураг 9.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС



Хэрэглээний үнийн индекс 2025 оны 7 дугаар сарыг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 3.9 хувиар өсөхөд Хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 8.5 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис бүлгийн үнэ 4.1 хувь, хувцас бөс бараа гутал бүлгийн үнэ 2.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 4.4 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 3.9 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний

бүлгийн үнэ 3.1 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ бүлгийн үнэ 1.2 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 3.3 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн үнэ 7.5 хувиар, даатгал санхүүгийн үйлчилгээ бүлгийн үнэ 6.1 хувиар, бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ 5.4 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.


Хүснэгт 12.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр


Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2024-VII</u> 2023-VII	<u>2025-VII</u> 2024-VII	<u>2025-VII</u> 2024-XII	<u>2025-VII</u> 2025-VI
Ерөнхий индекс	5.0	9.3	3.9	-0.1
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	4.4	7.5	8.5	0.3
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	3.8	6.7	4.1	1.1
Хувцас, бөс бараа, гутал	5.3	10.9	2.2	0.0
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	7.3	23.7	4.4	0.5
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	6.1	7.2	3.9	0.1
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	5.2	6.3	3.1	0.3
Тээвэр	-0.6	3.7	-0.2	-1.8
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	1.9	0.8	1.2	1.2
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.5	6.9	3.3	0.1
Боловсролын үйлчилгээ	21.2	20.4	0.0	0.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	8.1	10.4	7.5	0.0
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	2.3	6.1	6.1	0.0
Бусад бараа, үйлчилгээ	9.6	10.9	5.4	0.1

2025 оны 7 дугаар сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 418 төрлийн бараа, үйлчилгээний үнийг өмнөх сартай харьцуулахад 88 (21.1%) бараа үйлчилгээний үнэ өсөж, 35 (8.4%) бараа үйлчилгээний үнэ буурч, 295 (70.6%) бараа үйлчилгээний үнэ тогтвортой байв.


Зураг 10. НЭГ ШИРХЭГ ТАЛХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн VII сард, төгрөг



Зураг 11. НЭГ КИЛОГРАММ САВЛАСАН ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн VII сард, төгрөг




Зураг 12. НЭГ КИЛОГРАММ ХҮНСНИЙ НОГООНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн VII сард, төгрөг



Зураг 13.

НЭГ ЛИТР ТАРАГ, СҮҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн VII сард, төгрөг



Хүснэгт 13.

НЭГ КИЛОГРАММ МАХНЫ ЖИЖИГЛЭН ХУДАЛДАХ ДОЛОО ХОНОГИЙН ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөг

Үхрийн ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2020	10 524	11 412	11 660	11 735	11 939	12 640	12 758	11 751	11 237	10 684	11 074	11 208
2021	11 614	12 606	12 666	13 853	13 956	14 768	14 793	13 700	13 420	13 277	13 342	13 493
2022	14 059	13 999	14 255	14532	15 144	15 387	15 119	14 236	13 730	13 562	13 226	13 395
2023	13 610	14 416	15 072	16 747	18 476	20 100	19 040	16 436	16 277	15 688	15 542	15 842
2024	16 436	17 149	17 624	18 126	19 531	18 895	18 533	17 735	18 137	17 864	17 783	18 261
2025	19 073	19 637	19 932	20 064	20 280	21 285	21 524					


Хонины ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2020	8 590	9 593	9 763	9 836	10 125	10 385	10 648	9 864	9 169	8 551	8 632	8 579
2021	9 034	10 459	10 692	12 318	12 389	12 696	12 440	11 380	10 974	11 006	10 773	10 846
2022	11 530	11 939	12 585	12 620	12 705	12 803	12 358	11 526	11 022	10 238	9 806	9 918
2023	10 545	11 721	12 820	14 062	15 369	16 597	15 288	13 237	12 702	12 006	11 834	12 078
2024	12 923	13 776	13 917	14 628	16 054	16 355	15 294	14 745	14 510	14 245	14 088	14 697
2025	15 560	16 495	17 177	17 458	17 270	17 088	17 005					

2025 оны 7 дугаар сард хүнсний зах, супермаркет, бөөний төвүүдэд жижиглэн худалдаалагдаж буй үхрийн ястай махны


үнэ өмнөх сартай харьцуулахад 1.1 хувиар өссөн бол хонины ястай махны үнэ 0.5 хувиар буурсан байна.

Зураг 14.

НЭГ КГ ХОНЬ, ҮХРИЙН МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, төгрөг



Зураг 15. НЭГ ЛИТР ШАТАХУУНЫ ҮНЭ, өөрчлөлт орсон өдрөөр



Хүснэгт 14. ТҮЛШНИЙ ҮНЭ, төгрөг


Байршил	2023.VII.31			2024.VII.29			2025.VII.28		
	Түлшний мод шуудай (6-7 кг)		Сайжруулсан түлш 25 кг	Түлшний мод шуудай (6-7 кг)		Сайжруулсан түлш 25 кг	Түлшний мод шуудай (6-7 кг)		Сайжруулсан түлш 25 кг
	Хар мод	Нарс мод		Нарс мод	Хар мод		Хар мод	Нарс мод	
Чингэлтэй	6 500	6 000	3 750	7 000	7 500	3 750	7 500	7 000	3 750
Сүхбаатар	7 000	6 000	3 750	7 000	7 500	3 750	7 500	7 000	3 750
Цайз зах	6 500	6 000	3 750	7 500	8 500	3 750	8 000	8 000	3 750
Хангай зах	6 000	5 500	3 750	7 000	7 000	3 750	7 000	7 000	3 750
Дундаж үнэ	6 500	5 875	3 750	7 125	7 625	3 750	7 500	7 250	3 750

Хүснэгт 15. НЭГ ЛИТР ШАТАХУУНЫ ҮНЭ, төгрөг

ШТС	2024.VII.29					2025.VII.28				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	-	-	2 390	3 390	-	-	-	2 590	2 940	-
Петровис	3 910	2 370	2 390	3 390	-	3 510	2 370	2 590	2 940	-
Магнай трейд	3 910	-	2 390	3 390	-	3 510	-	2 590	2 940	-
Сод монгол	3 910	2 315	2 390	3 390	-	3 510	2 315	2 590	2 940	-
Шунхлай	3 910	2 350	2 390	3 390	-	3 510	2 350	2 590	2 940	-
Юнигаз	-	-	-	-	1 790	-	-	-	-	1 950
Дундаж үнэ	3 910	2 345	2 390	3 390	1 790	3 510	2 345	2 590	2 940	1 950

Зураг 16.

АМ.ДОЛЛАРЫН ХАНШИЙН САРЫН ДУНДАЖ ХӨДӨЛГӨӨН, төгрөг²



² Эх үүсвэр: Монголбанкны статистикийн мэдээлэл

Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ): Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left(\frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left(\frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left(\frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

I_{ct}^L – t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t – Тайлант үе

0 – суурь үе

P_t^i – i барааны тайлант үеийн үнэ

P_0^i – i барааны тайлант үеийн үнэ

q_0^i – i барааны тайлант үеийн үнэ

ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. ХҮИ-ийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан.



АЖ ҮЙЛДВЭР


Нийслэлийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 2.5 хувиар буурлаа.

Нийслэлийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 10.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 262.4 (2.5%) тэрбум төгрөгөөр буурлаа. Үүнд: уул уурхайн олборлолт 723.4 (11.3%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 5.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 723.4 (11.3%) тэрбум төгрөгөөр буурахад чулуун, хүрэн нүүрс олборлолт 1.9 (72.5%) их наядаар буурсан нь голлон нөлөөлжээ.

Зураг 17.

АЖ ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТ, САРААР, ТЭРБУМ ТӨГРӨГ



Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2025 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 5.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 723.4 (11.3%) тэрбум төгрөгөөр буурахад чулуун, хүрэн нүүрс олборлолт 1.9 (72.5%) их наяд төгрөгөөр, газрын түүхий тос, байгалийн хий олборлолт 91.8 (13.6%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2025 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 3.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 98.2 (3.2%) тэрбум төгрөгөөр өсөхөд мах боловсруулах үйлдвэрлэл 79.3 (32.8%) тэрбум төгрөгөөр, жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт 7.8 (31.1%) тэрбум төгрөгөөр, үр тарианы гурилын

болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүн үйлдвэрлэл 5.7 (4.2%) тэрбум төгрөгөөр, хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл 64.2 (24.6%) тэрбум төгрөгөөр, арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2.3 (11.1%) тэрбум төгрөгөөр, тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, сүрэл, дэрсэн эдлэл үйлдвэрлэл 710.3 (2.9 дахин) сая төгрөгөөр, химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 35.3 (19.9%) тэрбум төгрөгөөр, үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл 2.6 (4.8 %) тэрбум төгрөгөөр, резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл 5.4 (8.1%) тэрбум төгрөгөөр, төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл 34.1 (29.2%) тэрбум төгрөгөөр, машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар, үйлчилгээ

36.4 (23.4%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Цахилгаан, хий, уур, агааржуулалт 2025 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 353.4 (23.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 2025 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 118.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.4 (8.6%) тэрбум төгрөгөөр өсөхөд хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах, дахин ашиглах 7.3 (22.9%)

тэрбум төгрөгөөр, ус хуримтлуулах, ариутгах, түгээх үйл ажиллагаа 2.3 (3.0%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийслэлийн аж үйлдвэрийн салбар 2025 оны 7 дугаар сард урьдчилсан гүйцэтгэлээр 1.6 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт хийснээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар 63.1 хувийг, боловсруулах аж үйлдвэрлэл 26.2 хувийг, цахилгаан, хий, уур, агааржуулалт 9.7 хувийг, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 1.0 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2024		2025*		Өөрчлөлт	
		VII	I-VII	VII	VII	Дүн	Хувь
Уул уурхай, олборлох аж үйлдвэр							
Чулуун нүүрс	мян.т	1 312.0	7 994.5	1 350.0	7 014.3	-980.2	-12.3
Хүрэн нүүрс, бөөгнөрөөгүй	мян.т	585.0	5 189.6	271.3	2 770.6	-2 419.0	-46.6
Газрын тос	мян.барр	337.3	2 467.6	307.3	2 206.7	-260.9	-10.6
Цэвэршүүлээгүй алт	кг	931.5	4 595.9	981.1	3 898.6	-697.3	-15.2
Хайлуур жонш	мян.т	1.6	18.8	0.8	2.1	-16.7	-89.0
Мөнгөний баяжмал	т	1 515.4	10 820.9	976.9	6 925.2	-3 895.7	-36.0
Боловсруулах үйлдвэр							
Малын мах	т	629.4	11 140.4	988.8	13 696.8	2 556.4	22.9
Хиам	т	1 032.6	6 116.7	1 171.6	6 520.2	403.5	6.6
Боловсруулсан шингэн сүү	мян.л	4 505.3	33 528.2	4 486.7	35 124.4	1 596.2	4.8
Гурил	мян.т	4.4	59.7	4.9	62.5	2.8	4.7
Талх	т	2 484.6	15 816.1	2 130.9	15 353.0	-463.1	-2.9
Нарийн боов	т	2 171.6	13 292.2	2 185.5	13 720.0	427.8	3.2
Гоймон	т	152.2	3 197.7	192.0	1 887.2	-1 310.5	-41.0
Цэвэр спирт	мян.л	618.4	4 546.4	348.6	3 781.6	-764.8	-16.8
Цагаан архи	мян.л	1 642.8	18 205.0	1 041.2	9 654.5	-8 550.5	-47.0
Ус, ундаа, жүүс	сая.л	45.1	255.6	32.7	240.5	-15.1	-5.9
Янжуур тамхи	мян.блок	146.4	1 572.8	91.7	1 213.5	-359.3	-22.8
Сүлжмэл эдлэл-ноолуур	мян.ш	28.9	182.9	21.2	149.8	-33.1	-18.1
Самнасан ноолуур	т	87.7	369.3	120.7	623.2	253.9	68.8
Угаасан ноолуур	т	651.8	1 386.1	136.9	344.4	-1 041.7	-75.2
Нүүрсэн шахмал түлш	мян.т	-	244.6	3.3	166.9	-77.7	-31.8
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж							
Цахилгаан эрчим хүч	сая.квт.цаг	506.3	4 507.1	535.8	4 917.0	409.9	9.1
Дулааны эрчим хүч	мян.гкал	230.5	6 448.5	251.5	6 608.9	160.4	2.5
Усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулах болон орчныг дахин сэргээх үйл ажиллагаа							
Төвлөрсөн сүлжээгээр цэвэр, бохир ус дамжуулах, түгээх үйлчилгээ (уур, халуун уснаас бусад)	мян.м3	3 841.6	30 419.5	4 074.9	31 732.5	1 313.0	4.3

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2025 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 16.1 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 3.3 (25.3%) их наяд төгрөгөөр өслөө. Үүнд: уул уурхай, олборлолтын салбарын борлуулалт 2.5 (30.5%) их наяд төгрөгөөр, боловсруулах үйлдвэрлэл 382.8 (11.1%) тэрбум төгрөгөөр, цахилгаан, хий, уур, агааржуулалт салбарын

борлуулалт 352.9 (33.3%) тэрбум төгрөгөөр, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа салбарын борлуулалт 5.0 (4.5%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.


Гадаад зах зээлд 2025 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 9.8 их наяд төгрөгийн борлуулалт хийсний 9.5 их наяд

